


UCS 0303B:2025

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ




Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад
тавигдах шаардлага

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад
тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/05-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томьёо, тодорхойлолт	5
4. Ундны ус хангамжийн эх үүсвэрт тавигдах шаардлага.....	5
5. Хамгаалалтын бүсэд тавигдах шаардлага	7
6. Суурьшлын бүсэд ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын шаардлага.....	9
7. Анхаарах болон хориглох зүйлс.....	13
8. Шалгах хуудас	16
Ашигласан материалын жагсаалт.....	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ус хангамжийн эх үүсвэр	6
Зураг 2. Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс.....	7
Зураг 3. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс	8
Зураг 4. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хамгаалалт	8
Зураг 5. Суурьшлын бүсийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалт	9
Зураг 6. Эх үүсвэрийн хамгаалалтын бүс /эрүүл ахуйн хязгаарлалтын бүс/	9
Зураг 7. Ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдлын харагдах байдал.....	10
Зураг 8. Хамгаалалтын хашаа харагдах байдал.....	11
Зураг 9. Аюулгүй байдал харуул хамгаалалт харагдах байдал	12
Зураг 10. Гэрэлтүүлгийн шаардлага	12
Зураг 11. Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ	15
Зураг 12. Ус бохирдуулагч эх үүсвэрүүд	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шалгах хуудас	16
--------------------------------	----



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

Хот төлөвлөлт, хот байгуулалтад
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Хот төлөвлөлт, хот байгуулалт” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS0302B:2025 “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS0303B:2025 “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS0304B:2025 “Улаанбаатар хотын зуслангийн бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад ээлтэй хашаанд тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

17.06.25

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

25/05

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТ

UCS 0303B:2025

“НИЙСЛЭЛИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ХАМГААЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү хотын стандартыг ундны усны эх үүсвэртэй холбоотой усны барилга байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах хууль, журам, норм дүрэм, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн эх материалыг үндэслэл болгоно.

- Усны тухай хууль;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
- Газрын харилцаа, геодези, зурагзүйн газрын даргын 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн А/200 дугаар тушаал “Тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй, шалгуур үзүүлэлтүүд”;
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам;
- БНБД 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам;
- БНБД 40-04-16 Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж;
- БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 17/9 дугаар тогтоолын хавсралт “Нийслэлийн хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах дэд хөтөлбөр”;
- MNS 0899:2020 Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага;
- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 6694:2017 Хүрээлэн буй орчин. Усны нөөц, ус ашиглалт, хамгаалалт. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 4079:2016 Усны чанар. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS 6279:2011 Ус хангамж, ариун цэврийн байгууламж. Нэр томьёо, тодорхойлолт. Тайлбар толь.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Гадаргын ус – гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай бүхий усны сан бүхий газар дээрх ус, рашааныг;

Гол, мөрний урсац бүрэлдэх эх – гэж гадаргын урсцын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг хэлнэ;

Онцгой болон энгийн хамгаалалтын бүс – гэж усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг хэлнэ;

Эрүүл ахуйн бүс – гэж ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг хэлнэ;

Ус хангамжийн эх үүсвэр – гэж худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг хэлнэ;

Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө – гэж сав газрын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичгийг хэлнэ;

Усны бохирдол – гэж хүний шууд ба шууд бус үйл ажиллагааны улмаас байгалийн усны найрлага өөрчлөгдөж, усны чанар доройтохыг хэлнэ;

Усны чанар – гэж усны чанарын стандартад нийцэх эсэхийг илэрхийлэх физик, хими, биологийн цогц шинж чанарыг хэлнэ;

Ундны усны эх үүсвэр – гэж “усны эх үүсвэр” гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг хэлнэ.

4. УНДНЫ УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Аливаа унд ахуйд ашиглах усны эх үүсвэр нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:


- газрын доорх усыг эх үүсвэрээр сонгох тохиолдолд газрын доорх уст үеийн байрлал болон ус бүрэлдэх нөхцөлийг харгалзан орчны бохирдуулагч эх үүсвэр байгаа эсэхийг тогтоосон байх;
- гадаргын усыг сонгох тохиолдолд ус авах байрлалын болон уг байрлалаас дээш, доош газар нутгийн бохирдуулагч эх үүсвэр байгаа эсэхийг тогтоох;
- ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөц, чанарын үнэлгээг тодорхойлсон байх;
- ус хангамжийн эх үүсвэрийн ус татах байгууламж байрлах талбайд бохирдуулагч эх үүсвэр байгаа эсэхийг тодорхойлсон, авах арга хэмжээг тодорхойлсон байх шаардлагатай.

4.2. Газрын доорх усаар хангагдаж буй эх үүсвэр нь гадаргын усыг бодвол бохирдлын хувьд харьцангуй бага үүсдэг тул унд-ахуйн усанд хэрэглэх нь тохиромжтой.

4.3. Ус хангамжийн эх үүсвэрийг газрын доорх усаар хангахдаа дараах мэдээлэл, судалгааг боловсруулсан байна. Үүнд:

- ус хангамжийн эх үүсвэр байрлах газар нутгийн геологийн тогтоц, түүний гидрогеологийн нөхцөлийн үндсэн үзүүлэлтүүдийг судлан тогтоосон байх;
- сонгосон уст давхаргын төрөл, түүний дээд хил заагийн байрлах гүн (үнэмлэхүйн өндөр), зузаан (метр);
- ус агуулагч давхаргын чулуулгийн төрөл;
- уст давхаргын тэжээгдэх нөхцөл ба тэжээгдлийн муж (уст давхаргын нөхөн сэлбэлт);

- усны нөөцийн ерөнхий мэдээлэл (ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөц чанарын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсан байх).



Зураг 1. Ус хангамжийн эх үүсвэр (жишээ зураг)

- 4.4. Ус хангамжийн эх үүсвэрийг сонгоход шаардагдах эрүүл ахуй, ус зүй, гидрогеологийн нөхцөлийн талаар мэдээллийг цуглуулж судлах, байр зүйн зураг зохиох ажлыг усны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.
- 4.5. Тухайн нутаг дэвсгэрийн /ордын/ гидрогеологийн нөхцөлд дараахыг хамруулан ойлгоно. Үүнд:
- ус хангамжид ашиглах уст үеүдийн тэжээгдэх нөхцөл;
 - ус татамжийн орчны байр зүй, хөрс, эрүүл ахуйн үзүүлэлтүүд;
 - ашиглахаар төлөвлөсөн уст давхаргын үзүүлэлтүүд /уст үед, цооног дахь усны гүн, хөдөлгөөнт ба тогтонги түвшин, ундарга;
 - уст үе хоорондын ус нэвчүүлэлтийн зэрэг, тэжээгдлийн мужаас усны чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл;
 - ус татах байгууламжууд /худаг/ байрлаж байгаа орчны эрүүл ахуйн үзүүлэлт, хаягдмал цооног, худаг, уул уурхайн ухааш нүх, шингээх хүнхээл, хаягдлын цэг зэрэг бохирдлын болзошгүй эх үүсвэрийн байрлал, худаг хүртэлх зайн мэдээллийг орон зайн програмаар үзүүлэн харуулах;
 - ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүсийг тогтоох боломж, төлөвлөж байгаа эрүүл ахуйн бүсүүдийн хилийн заагийн газрын болон төлөвлөлтийн мэдээллүүдийг боловсруулах;
 - ус хангамжийн эх үүсвэрийн усанд боловсруулалт хийх шаардлага, хэрэгцээ, мэдээлэл;
 - эх үүсвэрийн ус татах байгууламжийн төлөвлөж байгаа бүтэц зохион байгуулалт, хийц, /ус хүлээн авах байгууламж, цооног, худаг, тэдгээрийн тохижилт/-ийн эрүүл ахуйн шаардлага, гадна бохирдлоос хамгаалагдсан байдал, тухайн нөхцөлд ундны сайн чанарын ус олборлох нөхцөл шаардлагуудыг хангасан байх;
 - тэжээгдлийн нэг мужид орших зэргэлдээх ус татах байгууламжийн талаарх мэдээлэл зэрэг багтана.

5. ХАМГААЛАЛТЫН БҮСЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 5.1.1. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон түүний тэжээгдлийн мужид усны нөөцийн өөрчлөлт, горим, чанарын талаарх мэдээ гарган авах зорилгоор байнгын хяналт-шинжилгээ хийнэ.
- 5.1.2. Ус хангамжийн газрын доорх эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоохдоо тухайн эх үүсвэрийн усны орд газрын усны хуримтлалыг бий болгож байгаа сав газрыг бүхэлд нь хамруулах буюу усны хагалбарын хилээр хязгаарлана.
- 5.1.3. Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс заавал тогтооно.

5.2. Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрт тухайн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоож, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно. Үүнд:


- Эрүүл ахуйн хориглолтын;
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүсээс тогтоно.

5.3. Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдөж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглоно.




Зураг 2. Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс (жишээ зураг)

5.4. Улсын нэгдсэн хяналт-шинжилгээний сүлжээнээс гадна хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалтын /ус хангагч/ байгууллага нь тухайн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс болон түүний тэжээгдлийн мужид хяналт-шинжилгээ хийж дүнг нэгтгэн холбогдох хяналтын байгууллагуудад тогтоосон хугацаанд хүргүүлэх шаардлагатай.



Зураг 3. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс (жишээ зураг)

- 5.5. Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.
- 5.6. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд дараах шаардлагыг хангана. Үүнд:
 - эрүүл ахуйн хориглолтын бүсэд гадаргуугийн урсцыг тус бүсээс зайлуулах суваг байгуулна;
 - эх үүсвэрийг ашиглах зориулалттай барилга байгууламжийг ариутгах татуургын төвлөрсөн системд холбоно. Хэрэв боломжгүй бол стандартын шаардлага хангасан бохир усны цооног, бие засах газрыг бүсийн гадна байрлуулна;
 - ус хангамжийн барилга байгууламжид засвар, өргөтгөлийн ажил хийхдээ байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.
 - ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн эргэн тойрныг хашиж хамгаалан байнгын харуул хамгаалалттай байлгах бөгөөд худаг, усан сангийн таг, салхивчийг хялбар нээх, эвдэх боломжгүй байхаар битүүмжлэн тохижуулсан байх;



Зураг 4. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хамгаалалт (жишээ зураг)

- тухайн бүсийн талбайг тогтмол цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж, хөнөөлт шавж мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар механик аргаар хийлгэх;
- ус хангамжид ашиглахаар төлөвлөж буй эх үүсвэрийн гидрогеологийн нөхцөлөөс шалтгаалан эрүүл ахуйн бүсэд нэмэлт арга хэмжээ авч болно.


6. СУУРЬШЛЫН БҮСЭД УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ШААРДЛАГА

6.1. Ундны усны эх үүсвэрийн нөлөөллийн бүсэд хяналт туршилтын цооногийг хамгийн багадаа 10 метрээс 2 км хүртэлх зайд байрлуулан усны нөөцийн мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.



Зураг 5. Суурьшлын бүсийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалт (жишээ зураг)


6.2. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.



Зураг 6. Эх үүсвэрийн хамгаалалтын бүс /эрүүл ахуйн хязгаарлалтын бүс/

6.3. Ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:



- хамгаалалтын хашаа;
- аюулгүй байдлын хяналт;
- камержуулалт;
- гэрэлтүүлэг.



Зураг 7. Ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдлын харагдах байдал (жишээ зураг)

6.3.1 Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашаа нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- хашааны суурийн бетоныг В20 ангиас багагүй, хүйтэнд тэсвэрлэлтийн зэрэг 50 мөчлөгөөс багагүйгээр тооцох;
- хашааны суурийн байгууламжийг суурилуулахдаа БНБД 3.01.06-90-д заасан шаардлагын дагуу хийж гүйцэтгэх;
- хашааны материал нь өндөр чанартай бага нүүрстөрөгчийн ган болон цайрдсан материалын дээгүүр ус тусгаарлах, зэврэлтээс сэргийлэх зорилгоор PVC материалаар шүршиж бүрсэн төмөр байх;
- хашааны өндөр 1.6-3.0м хүртэл байх /Суурьшлын бүсээс зайдуу үед байгаль орчинд ээлтэй зэрлэг амьтдад аюул учруулахааргүйгээр тооцон хашааны өндрийг тогтооно/;
- тулгуур хоорондын зай 2500мм-ээс ихгүй байх;
- төмөр утас диаметр 4мм-ээс багагүй байх;
- суурийн өндөр 250мм-ээс багагүй, өргөн нь 300мм-ээс багагүй байхаар гүйцэтгэх.



Зураг 8. Хамгаалалтын хашаа харагдах байдал (жишээ зураг)

6.3.2 Аюулгүй байдал харуул хамгаалалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- төвлөрсөн ундны усны эх үүсвэр нь 24 цагийн камержуулалт хяналтын посттой байна.
- суурьшлын бүсээс зайдуу эх үүсвэрийн хувьд байнгын хяналтын пост байрлуулах боломжгүй тохиолдолд 24 цагийн камерын хяналт тухайн нутаг дэвсгэрийн холбогдох хяналт, хүчний албадын бэлэн байдлыг хангасан байх
- тухайн хамгаалалтын бүсэд тэмдэглэгээ, тэмдгийг холбогдох баримт бичгийн дагуу байрлуулсан байх шаардлагатай.
- нөөц цахилгаан хангамжтай байх хэрэгтэй.
- галын аюулгүй байдлыг хангасан байвал зохино.
- хяналтын постыг эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд байрлуулахдаа стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангасан байна.

6.4. Камержуулалт, гэрэлтүүлгийн дараах шаардлага ундны эх үүсвэрт тавигдана. Үүнд:

- ундны усны эх үүсвэр бүрд стандартын шаардлага хангасан шөнийн гэрэлтэй, хөдөлгөөн мэдрэгчтэй гадна камерыг суурилуулсан байх;


- камер тус бүрийг нэгдсэн төв мэдээллийн санд холбосон байх ба санах ойг багадаа 90 хоног хадгалдаг байхаар сонгон ашиглах;
- камерын ажиллагаанд доголдол гарсан үед цаг алдалгүй засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг хангаж байх.



Зураг 9. Аюулгүй байдал харуул хамгаалалт харагдах байдал (жишээ зураг)

6.4.1 Гэрэлтүүлэг нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Гэрэлтүүлгийн шонг сонгохдоо тухайн хамгаалалтын бүсийг бүрэн гэрэлтүүлэхээр тооцон хоорондын зайг 10м-ээс хэтрүүлэхгүйгээр байрлуулах;
- Гэрэлтүүлгийн шонг газарт суурилуулахдаа холбогдох норм дүрмийн дагуу тооцоолон хамгийн багадаа газрын 0 түвшнээс доош 800мм-ээс багагүй ухаж суурилуулсан байх шаардлагатай;
- Гэрэлтүүлэг сонгохдоо суурьшлын бүсээс хол үед нарны зай хураагуур ашиглан цахилгаан хангамжаа шийдэх;
- Гэрэлтүүлгийн шонг газардуулагчтай гүйцэтгэсэн байх;
- Гэрэлтүүлгийг сонгохдоо доорх зургийн шаардлагын дагуу тооцож байрлуулбал зохино.



Зураг 10. Гэрэлтүүлгийн шаардлага (жишээ зураг)

7. АНХААРАХ БОЛОН ХОРИГЛОХ ЗҮЙЛС

7.1. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
- ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;
- цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
- уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
- судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх; төвлөрсөн ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээтэй газар унд ахуйн зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
- бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;
- газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох.

7.2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой зүйлд болон нэмж дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

- гадны хүн орох;
- авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;
- мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих.
- ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрийн тэжээгдлийн болон нөлөөллийн мужид цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис үйлдвэрлэх, тэдгээрийг ашиглан аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.3. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, ус түгээх шугам, ус түгээх цэгт эрүүл ахуйн бүс тогтоож тэмдэгжүүлсэн байна.

7.4. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг тогтооно.

7.5. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашиглавал түүний эргээс 200 метрээс доошгүй зайд, урсгал усны хувьд урсгалын дээд талд 50 км-ээс доошгүй, доод талд 500 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.

7.6. Нийт урт нь 40 км-ээс бага урсгал усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглавал ус хурах талбайг бүхэлд нь хамааруулан эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.


7.7. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээгдлийн муж болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хурах талбайг хамруулан тогтоож болно.

- 7.8. Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш 5 метрт эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.
- 7.9. Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.

АНХААР! ОНЦГОЙ ХАМГААЛАЛТЫН БҮС	
Ундны усны эх үүсвэрийн онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг тэмдэглэсэн самбар.	Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулахыг хориглоно.
	
Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрийн тэжээгдлийн болон нөлөөллийн мужид цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис үйлдвэрлэх, тэдгээрийг ашиглан аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглахыг хориглоно.
	
Ариун цэврийн байгууламж байршуулахыг хориглоно.	Гадны хүн зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно.
	
Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлохыг хориглоно.	Ашигт малтмал олборлох, газар хагалах, тэсэлгээ хийхийг хориглоно.

	
Мал бэлчээх, угаах, мал аж ахуй, хөдөө аж ахуй эрхлэхийг хориглоно.	Газар тариалан болон ногоо тарихыг хориглоно.

Зураг 11. Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ



Зураг 12. Ус бохирдуулагч эх үүсвэрүүд (жишээ зураг)

8. ШАЛГАХ ХУУДАС

Ашиглагдаж байгаа болон шинээр эх үүсвэрийн барилга байгууламж байгуулах, дэглэмийн хэрэгжилтийг гаргахад ашиглана.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын хил хязгаарыг тогтоон, тэмдэгжүүлсэн эсэх	☐	☐
2	Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын хил хязгаарыг тогтоон, тэмдэгжүүлсэн эсэх	☐	☐
3	Ундны усны эх үүсвэрийн усны нөөцийн хяналт мониторинг хийдэг эсэх	☐	☐
4	Ундны усны эх үүсвэрийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж холбогдох байгууллагад хүргүүлдэг эсэх	☐	☐
5	Ундны усны эх үүсвэрийн бүсэд газар олголт хийгдсэн эсэх	☐	☐
6	Ундны усны эх үүсвэрийн бүсийн хил хязгаарыг тогтоон хашаа хайс байрлуулж тэмдэгжүүлсэн эсэх	☐	☐
7	Аюулгүйн тэмдэглэгээ хийсэн эсэх	☐	☐
8	Ундны усны эх үүсвэрийг харуул хамгаалалтаар хамгаалдаг эсэх	☐	☐
9	Ундны усны эх үүсвэр орчмыг камержуулсан эсэх	☐	☐
10	Ундны усны эх үүсвэрийн холбогдох цооног, худаг, худгийн таг зэрэг хэрэгслүүдийг тэмдэгжүүлсэн эсэх	☐	☐
11	Улсын онцгой объектын тэмдэг байршуулан хүн мал орохоос сэрэмжлүүлсэн эсэх	☐	☐
12	Ундны усны эх үүсвэрийн бүсэд хог хаягдалтай эсэх	☐	☐

Тайлбар: Ашиглагдаж байгаа болон шинээр эх үүсвэрийн барилга байгууламж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ. “Үгүй” гэсэн тэмдэглэл хийгдсэн хэсгийг заавал тухайн шаардлагад нийцүүлэн сайжруулах үүргийг тухайн эх үүсвэрийг эзэмшигч гүйцэтгэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль;
- Усны тухай хууль;
- Эрүүл ахуйн тухай хууль;
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам;
- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ;
- MNS 0899:2020 Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага;
- MEULI, C.; WEHRLE, K. (2001): Spring Catchment. St. Gallen: Swiss Centre for Development Cooperation in Technology and Management (SKAT). URL: <http://www.skat.ch/publications/prarticle.2005-09-29.5069774463/prarticle.2006-11-02.8410562785/skatpublication.2005-10-27.4727403982/file> [Accessed: 22.03.2012];
- MEULI, C.; WEHRLE, K. (2001): Spring Catchment. St. Gallen: Swiss Centre for Development Cooperation in Technology and Management (SKAT). URL: <http://www.skat.ch/publications/prarticle.2005-09-29.5069774463/prarticle.2006-11-02.8410562785/skatpublication.2005-10-27.4727403982/file> [Accessed: 22.03.2012].
- <https://unhabitat.org/sites/default/files/2022/09/380721eng.pdf>.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар